МАГАДЛАЛ - 3

1. Хэлбэр хэмжээгээрээ ижил 13 улаан , 13 цэнхэр бөмбөгийг тэнцүү тоотой 2 хэсэгт санамсаргүйгээр хуваахад аль нэг хэсэгт нь 10 улаан , 3 цэнхэр бөмбөг байх магадлалыг ол. /2008он/

   (A) $\frac{A_{13}^{3}A_{13}^{10}}{A_{26}^{13}}$ (B) $\frac{1}{13}$ (C) $\frac{C_{13}^{3}C_{13}^{10}}{C_{26}^{13}}$ (D) $\frac{(C_{13}^{3})^{2}}{2C_{26}^{13}}$ (E) $\frac{1}{7}$

2. Хайрцагт 6 улаан, 4 хөх бөмбөг байв. Хайрцагнаас таамгаар 2 бөмбөг буцааж хийхгүйгээр дараалан нэг нэгээр нь авахад эхэлж авсан бөмбөг нь улаан, дараа нь авсан бөмбөг хөх байх магадлалыг ол. /2015он/

   (A) $\frac{4}{15}$ (B) $\frac{15}{64}$ (C) $\frac{15}{28}$ (D) $\frac{5}{16}$ (E) $\frac{25}{64}$

3. Хэлбэр хэмжээгээрээ ижил 13 улаан , 13 цэнхэр бөмбөгийг тэнцүү тоотой 2 хэсэгт санамсаргүйгээр хуваахад аль нэг хэсэгт нь 13 улаан бөмбөг байх магадлалыг ол. /2008он/

   (A) $\frac{1}{7}$ (B) $\frac{1}{13}$ (C) $\frac{1}{C_{26}^{13}}$ (D) $\frac{2}{C_{26}^{13}}$ (E) $\frac{1}{A_{26}^{13}}$

4. Уутанд 3 хөх, 6 улаан, 4 шар бөмбөг байв. Уутнаас таамгаар 2 бөмбөг авахад ижил өнгийн бөмбөг таарах магадлалыг ол. /2010он/

   (A) $\frac{3}{7}$ (B) $\frac{3}{13}$ (C) $\frac{4}{13}$ (D) $\frac{1}{2}$ (E) $\frac{3}{5}$

5. ''Сонголт'' гэдэг үгнээс 2 үсэг дарахад хоёулаа гийгүүлэгч байх магадлалыг олоорой. /2016он/

   (A) $\frac{1}{3}$ (B) $\frac{5}{7}$ (C) $\frac{7}{9}$ (D) $\frac{10}{21}$ (E) $\frac{4}{5}$

6. Нэгж радиустай дугуй дотроос таамгаар нэг цэг авахад дугуйн төвөөс $\frac{1}{5}$ – ээс бага зайд байх магадлалыг ол. /2015он/

   (A) $\frac{1}{25}$ (B) $\frac{1}{2}$ (C) $\frac{24}{25}$ (D) $\frac{4}{5}$ (E) $\frac{1}{5}$

7. Бүх талс нь будагтай кубыг 1000 ширхэг тэнцүү кубэд хуваасан. Эдгээр кубүүдээс таамгаар 1-г сонгоход зөвхөн 1 талс нь будагтай куб таарах магадлалыг ол. /2012он/

   (A) $\frac{12}{125}$ (B) $\frac{1}{125}$ (C) $\frac{243}{500}$ (D) $\frac{64}{125}$ (E) $\frac{48}{125}$

8. Гар утасны дугаарын эхний 4 оронгийн цифрүүдийн нийлбэр сүүлчийн 4 оронгийн цифрүүдийн нийлбэртэй тэнцүү байвал ''аз''-тай дугаар гэе. 99945**9 хэлбэрийн дугаартай хэрэглэгч азтай дугаар барих магадлалыг ол. /2014он/

   (A) 0.02 (B) 0.2 (C) 0.04 (D) 0.05 (E) 0.01

9. Дөрвөн хүүхэдтэй айл хоёр хүү хоёр охинтой байх магадлалыг ол. /2011он/

   (A) $\frac{1}{8}$ (B) $\frac{1}{4}$ (C) $\frac{1}{2}$ (D) $\frac{3}{8}$ (E) $\frac{5}{8}$

10. Түрийвчинд 20000-тын дэвсгэрт 5ш, 10000-тын дэвсгэрт 6ш, 5000-тын дэвсгэрт 4ш байв. Таамгаар нэг дэвсгэрт сугалахад 5000-тын дэвсгэрт байх магадлалыг ол. /2016он/

    (A) $\frac{4}{15}$ (B) $\frac{1}{3}$ (C) $\frac{4}{5\cdot4\cdot6}$ (D) $\frac{6}{15}$ (E) $\frac{11}{15}$



LIVEWORKSHEETS